

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 28-ны өдөр

Дугаар__

Улаанбаатар хот

КОМПАНИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.15, 62.1.16 дахь заалт болон 2018 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 18/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэсэн Жинст Увс ХК-ийн 2017 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

ЖИНСТ УВС ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 28-ны өдөр

Дугаар__

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт болон 2018 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 18/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Дараах гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлд сонгон томилсугай. Үүнд:

Ердийн гишүүдээр:

1. Ч.Ганхуяг,
2. А.Батболд,
3. П.Батбаяр,
4. Г.Цогбадрах,
5. С.Халиунаа,
6. М.Сэргэлэн,

Хараат бус гишүүдээр:

1. А.Азбаяр,
2. Б.Солонго,
3. Б.Гантулга.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

ЖИНСТ УВС ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 28-ны өдөр

Дугаар__

Улаанбаатар хот

Компани нэгтгэх үйл ажиллагааны тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, “Жинст Увс” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг Жинст Увс ХК-тай нэгтгэх замаар хоёр компанийг өөрчлөн байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Нэгтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор компани хооронд нэгтгэх гэрээг нэгдүгээр хавсралтаар, нэгтгэх журам, төслийг хоёрдугаар хавсралтаар, нэгдэж байгаа компани буюу Ард санхүүгийн нэгдэлийн үнэт цаасыг нэгтгэж байгаа компани Жинст Увсийн үнэт цаасад хөрвүүлэх журмыг гуравдугаар хавсралтаар баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ч.Ганхуяг/-д даалгасугай.
3. Нэгтгэх үйл ажиллагаатай холбоотойгоор компаний дүрмийг шинэчлэн батлах Улсын бүртгэлийн газар болон Татвар, санхүүгийн холбогдох байгууллагад бүртгүүлэх болон холбогдох бусад арга хэмжээ авах ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ч.Ганхуяг/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

ЖИНСТ УВС ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 28-ны өдөр

Дугаар__

Улаанбаатар хот

Компани нэгтгэх үйл ажиллагаатай холбогдуулж,
компанийн нэрийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, “Жинст Увс” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг Жинст Увс ХК-тай нэгтгэн өөрчлөн байгуулж, “Жинст Увс” компанийн нэрийг “Ард Санхүүгийн Нэгдэл” болгон өөрчилсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

ЖИНСТ УВС ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 28-ны өдөр

Дугаар__

Улаанбаатар хот

Компани нэгтгэх үйл ажиллагаатай холбогдуулж,
компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, “Жинст Увс” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Жинст Увс ХК-д Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг нэгтгэж буйтай холбогдуулж компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

ЖИНСТ УВС ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4-р сарын 28-ны өдөр

Дугаар__

Улаанбаатар хот

Компани нэгтгэх үйл ажиллагаатай холбогдуулж,
үйл ажиллагааны чиглэлт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, “Жинст Увс” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн үйл ажиллагааны чиглэлд “хөрөнгө оруулалт”-н үйл ажиллагааг нэмж, компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг оруулсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ